



МОНГОЛ
УЛСЫН
БУСГА
УРГАМОН
УНДГАЙН
УУЛСЫН
УРГАМОН

Өгий нуурын алгана (*Perca fluviatilis*) загасны биологи, экологийн судалгаа

Н.Түвшинлхагва (МА)

МУБИС, МБУС-ийн биологийн тэнхим

Улаанбаатар, 2015



Судалгааны зорилго

Бид Өгий нуурын алгана загасны биологи, экологийн судалгааны ажлыг хийх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьсан. Үүнд:

- Алгана загасны үржил, насны бүрэлдэхүүн, өсөлт, тарга авалт, идэш тэжээлийн бүрэлдэхүүнийг тогтоох
- Өгий нуурын алгана загасны экосистемд гүйцэтгэх үүрэг, агнуурт эзлэх хувийг тодорхойлох



Судалгааны арга зүй ба материал:

Өгий нуурын алгана загасны судалгааг 2005-2010 оны өвөл, зун, намрын улиралд хийж бэлчээрлэн идээшилж байгаа ба өвөлжилтийг тогтоосон. Судалгаанд 1,0–2,5 м өндөртэй, 30х30–80х80 мм нүдтэй, 100 м хүртэл урттай залмагайн торыг ашиглан загас барьсан.



Судалгааны арга зүй ба материал:

Нийт 76 алгана загас барьж хэмжин, жигнэж өөхжилтийг Иортын шкал, ходоод гэдэсний дүүргэлтийн зэргийг Лебедевийн баллаар ялган тодорхойлоно. Алгана загасны нас тодорхойлох залмагайн хавхаг-Operculum, идэш тэжээлийг тодорхойлохын тулд ходоодыг авч 3-5% формалины уусмалд бэхжүүлэн лабораторит тодорхойлсон.



Судалгааны үр дүн:

Зураг-1.
Өгий нуурын алгана загасны үржил явагдаж буй газар



Үржил:


Алгана 4-р сарын сүүлээс 6-р сарын эхний хагаст түрсээ шахна. Түрслүүр газар нь усны ургамал элбэгтэй Хөгшин Орхон голын Өгий нуурт цутгах хэсэг, хуучин загасан заводын баруун урд хэсэг болох 1 м орчим гүехэн газар түрсээ шахаж байсан (Зураг-1).



Судалгааны үр дүн:

Диаграмм-1 .

Өгий нуурын алгана загасны насны бүрэлдэхүүн (2005.09 - 2006.11сар).



Нас, өсөлт:

Өгий нуурын алгана загасны биеийн хэмжээ, жилийн өсөлт 5–6 насанд хамгийн их байна. Алгана загас 3-4 насандаа бэлэг боловсрол гүйцэж, 210-360 мм, 110-520 г жинтэй болж агнуурт өртөгдөж эхэлдэг. Бидний судалгаанд 6-7 насны бодгаль нийт загасны 58%-ийг эзлэсэн нь залуу популяци давамгалаж байна (Диаграмм-1).



Судалгааны үр дүн:

Өгий нуурын алгана загасны биеийн хэмжээ, өсөлт, агнуурт эзлэх хувь /2005.09 – 2006.11/


Насны бүрэлдэхүүн	4+	5+	6+	7+	8+	9+
Агнуурт эзлэх хувь	5,2	19,7	31,6	26,3	13,1	3,9
Биеийн урт – L /мм/	261,6	290,6	340,4	381,4	395,5	390,0
Биеийн жин – Q /г/	200,0	352,6	575,0	778,0	850,0	1000,0
Алгана загасны тоо	4	15	24	20	10	3



Судалгааны үр дүн:

Диаграмм-2 .

Өгий нуурын алгана загасны идэш тэжээлийн бүрэлдэхүүн (2005.09 – 2006.11).




Идэш тэжээл:

Зуны судалгааны явцад бие гүйцсэн алгана загасны ходоод дүүргэлтийн итгэлцүүр 3-5 баллтай байсан. Тэжээлийн индексийн хэлбэлзэл нь 13,3–454,5 дунджаар 126,75‰ байгаа нь алгана загас ихээхэн ховдог болох нь ажиглагдаж байна. Тэжээлийн олдоц бага үед өөрийн үр төлөө ч барьж идэж байсан (Диаграмм-2).



Судалгааны үр дүн:

Диаграмм-3.



Тарга авалт:


Өгий нуурын алгана загасны тарга авалт Фультон ба Кларкын коэффициентын дунджаар $\Phi=1,4$, $K=1,15$ байгаа нь Өгий нуурт алгана загасны идэш тэжээлийн хүрэлцээ хангамжтай, тарга авалт сайн байгааг харуулж байна (Диаграмм-3).



Судалгааны үр дүн:

Диаграмм-4.

Өгий нуурын зун, өвлийн улиралд агнуурт эзлэх загасны хувь



Өгий нуурын алгана загасны экосистемд гүйцэтгэх үүрэг, агнуурт эзлэх хувь:

Алгана ихэвчлэн усны гүн, задгай газарт ганц ганцаар амьдарна. Алгана загас холын нүүдэл хийдэггүй, хавар зуны улиралд эрэг бараадаж байгаад намар гүн тийш шилжинэ. Залуу, өсвөр загас цурхай загасны хоол тэжээл болдог. Бие гүйцсэн загас усны шавж, бусад загасаар хооллоно. Алгана загас Өгий нуурт өргөн тархалттай бөгөөд аль ч улиралд загас агнуурын 40 гаруй хувийг дангаараа эзлэж байна (Диаграмм-4).



Дүгнэлт

- Өгий нуурын алгана загасны гүний ба улирлын тархац, байршлын хувьд нуурын бүх хэсгээр жигд тархалттай байгаа ба нуурын их гүн болох 15,6 м-ийн гүнээр ч идээшилж байсан. Алгана загасны үржлийн газар хумигдаж, цутгал голыг хашин боож их хэмжээгээр агнаж байгаа нь алгана загасны популяцийн нягтшилд сөргөөр нөлөөлөн, зарим жил үржиж чадалгүй үлдэх тохиолдол гарч байна.
- Насны бүрэлдэхүүний хувьд 4–9 насны 6 бүлэгт хамрагдаж, агнуурт 6–7 насны загас зонхилож байсан.
- Тэжээлийн бүрэлдэхүүний зонхилох хувийг улааннүдэн, ердийн варлан эзлэж, усны шавж (цох, бясаа), шаамий хавч зэрэг бентос амьтнаар хооллож, зарим үед өөрийн жараахайгаар хооллодог канаболизмын шинж тэмдэг ажиглагдаж байсан. Иймд алгана загас идэш тэжээлийн хомсдолд ордоггүй болох нь ажиглагдсан. Идэш тэжээлийн хүрэлцээ хангамж сайтай учир тарга авалт сайн байсан.



Хэлцэл. . .

- Загасны үржлийн үед хамгаалалтыг сайжруулахад хууль хяналтын ажлыг эрчимжүүлэх, тэдний хариуцлагыг өндөржүүлэн шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангаж өгөх.
- Агнасан загасны тоо хэмжээ, загасны зүйлийн бүрдлийн харьцаа, гарцын талаар мэдээлэлийг цуглуулан холбогдох газар ялангуяа ЭШ-ний байгууллагад хүргүүлэж байх тогтолцоог бүрдүүлэх. .
- “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн 17 дугаар зүйлийг үндэслэн загасчидаас загас барьсан төлбөрийг авч түүнээс олсон орлогын тодорхой хувийг загасны нөхөн төлжилт, экологийг сэргээх ажилд зориулах.
- Өгий нуурыг тойрон хууль бусаар загас агнуур хийж аж төрдөг айл өрх болон жуулчны баазуудын хараа хяналтыг сайжруулан, тэдгээрт тавих шаардлагыг өндөржүүлэх.
- Жуулчны баазын тоо нэмэгдсэнээр хог хаягдал ихсэн, нуурын усанд орж, угаалгын бодис саван хэрэглэж усны чанар, загасны амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх болсны улмаар Өгий нуурын экосистемийг хамгаалах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Анхаарал тавьсанд баярлалаа

